

Цөмийн энергийн салбарын эрх зүйн орчны шинэчлэлт

Э.Нямдаваа, Г.Манлайжав, Б.Баатарцогт, М.Чадраабал, Г.Гэрэлмаа

Цөмийн энергийн комиссын Ажлын алба

e.nyamdavaa@nea.gov.mn

Хураангуй

Монгол Улс дахь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны эрх зүйн орчин, тэр дундаа өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг дүрэм, журмууд 1983 оноос хойш шинэчлэгдээгүй байсан тул Олон улсын атомын энергийн агентлагийн стандарт, Европын холбоо болон бусад орны туршлагыг судлан олон улсын жишигт хүргэх ажлыг гүйцэтгэв. Энэ ажлын хүрээнд цөмийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах чиглэлээр 20 дүрэм, журам, норм, стандарт, төлөвлөгөөг боловсруулж батлуулав. Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглахад аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах болон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх чиглэлээр олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн оров. Мөн цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зарчмын шаардлагуудыг тусгав.

Түлхүүр үгс: цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

ОРШИЛ

Монгол Улсад эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээ, аж үйлдвэр, барилга, автозам, нисэх, хил гааль, хөдөө аж ахуй, геологи, уул уурхай, хяналт шалгалт зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт цөмийн технологи, цацраг идэвхт материал, цацрагийн үүсгүүрийг өргөн ашиглаж байна. Байгалийн зүй тогтлоороо уран болон торийн задралын бүлийн цөмүүд газар шороо, агаар, ус, ургамалд агуулагддаг тул хоол хүнс, ундны ус, барилгын материал зэрэг өргөн хэрэглэгддэг бараа бүтээгдэхүүнд байгалийн цацраг идэвхт цөм тодорхой хэмжээгээр агуулагддаг билээ.

Цөмийн технологи, цацраг идэвхт материал, ионжуулагч цацрагийн үүсгүүр, тэдгээрийн хэрэглээний ач тус нь учруулж болзошгүй эрсдэлээс үлэмж их буюу цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг зохих түвшинд хангаж, тунгийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байх тохиолдолд үүнийг ашиглах үндсэн зарчимтай. Мөн цацрагтай холбоотой үйл ажиллагаандаа ALARA (as low as reasonably achievable) зарчмыг хангахыг эрмэлздэг. Цацрагтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн аюулгүйн норм, дүрэм, стандартыг чанд мөрдөж, ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс өнөө ба ирээдүйд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалж, аюулгүй ажиллагааг хангах нь нэн тэргүүнд тавигдах чухал асуудал юм.

Монгол Улсын хэмжээнд ионжуулагч цацрагтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулахад БНМАУ-ын Ариун цэврийн ерөнхий байцаагчийн 1983 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Цацрагийн аюулгүйн норм ЦАН-83”, “Цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн бусад үүсгүүртэй ажиллах ариун цэврийн үндсэн дүрэм ЦАЦҮД-83”-ыг 2015 он хүртэл мөрдөж байв [1], [2].

Олон улсын хэмжээнд цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн стандартыг Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Цөмийн энергийн агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулж, ОУАЭА-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар 1962 онд

батлан гаргаж, 1967, 1982, 1996 онд шинэчилсэн байна. Тус стандартыг 2014 онд Европын комисс, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ОУАЭА, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Цөмийн энергийн агентлаг, Пан Америкийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэрэг олон улсын 8 байгууллага хамтран боловсруулж, шинэчлэн баталсан байна [3].

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.1-д “байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах” гэж заасан байдаг. Энэ хүрээнд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар заасан байдаг. Тодруулбал, Ирээдүй өв сан, төсвийн тогтворжуулалтын сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд улсын төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс нэн тэргүүнд хуваарилж, түүнээс үлдэх хэсгийн 65 хувийг, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх ерөнхий зохицуулалтыг тусгасан.

Дээрх сангуудын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнийг нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулан тооцохтой холбоотой асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулсан байдаг боловч Цөмийн энергийн тухай хуульд эдгээр зохицуулалт тусгагдаагүй, тодорхойгүй орхигдсон байна.

Түүнчлэн дээрх “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Хуулийн зохицуулалтыг Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч байх зарчимд нийцүүлэх, Гадаад улсын цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох зохицуулалтыг тусгах” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсад цацраг идэвхит ашигт малтмалын 13 орд (Дорнод, Гурванбулаг, Улаан, Нэмэр, Мардайн гол, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч-Овоо, Энгэр ар, Далт)-ын хэмжээнд 192.2 мян.тонн геологийн нөөц бүртгэгдэж, үүнээс 11 ордын нөөцийг Эрдэс баялгийн

мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэж-авсан байна.

ОУАЭА-ийн ураны олборлолт, эрэлт, нийлүүлэлтийн талаар 2022 оны хэвлэлд мэдээлснээр дэлхийн хэмжээнд 6.1 сая тн ураны нөөц байна. Тус нөөцийн 93% нь 13 улсад тогтоогдсон ба Австрали Улс 1.6 сая тн, Казахстан Улс 906 мян.тн, Канад Улс 594 мян.тн ураны нөөцтэйгөөр тэргүүлж байгаа бол Монгол Улс 192,000 тн ураны нөөцөөр дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж 10 дугаар байрт жагсаж байна [4].

Дээрх тайланд дурдсанаар 2022 оны байдлаар 15 орон 49'355 тн уран, үүний 56 хувийг газрын дор уусган олборлох аргаар, 38 хувийг уламжлалт уурхайн аргаар, 6 хувийг дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр тус тус олборлосон байна. Уг статистик мэдээллээр 2022 оны нийт олборлолтын 78 хувийг 4 улс буюу Казахстан (21'227 тн), Канад (7'351 тн), Намиби (5'613 тн), Австрали (4'553 тн) тус тус олборлоод байна.

Цөмийн эрчим хүчний салбарт хэрэглэх ураны хэрэгцээ 2024 онд 67'517 тн уран байгаа бол нүүрстөрөгчийн ялгарлыг тэглэх зорилтыг биелүүлэхийн тулд 2030 он гэхэд ураны эрэлт 83'840 тн болж 28 хувиар, 2040 он гэхэд 130'000 тн-д хүрч 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Ойрын жилүүдэд бага оврын реактортой цөмийн цахилгаан станцын үйлдвэрлэл зах зээлд нэвтрэх боломжтой байгаа бөгөөд 2035 он гэхэд тус станцын зах зээл 21 ГВт хүрэх боломжтой гэж дээрх тайланд дурдсан байна.

Ураны уурхайнууд 2022 онд 49'355 тн уран нийлүүлсэн нь тухайн жилийн нийт хэрэгцээний 74%-ийг хангасан бол үлдсэн хувийг хоёрдогч эх үүсвэрээс бүрдүүлсэн.

Нөөц баялаг, олборлолтоороо дэлхийд тэргүүлэгч 13 орны хувьд цацраг идэвхт ашигт малтмалын ордод төрийн оролцоог авч үзвэл цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай, өсөн нэмэгдэх төлбөр нь олборлолтын хэмжээ болон үнээс хамааруулан дунджаар 3-10% байдаг ба хөрөнгө оруулалтын гэрээнд үндэслэж төрийн хувь, эзэмшлийн асуудлыг зохицуулж байна.

Тухайлбал, Дэлхийд ураны нөөцөөрөө 2-т (13 хувь), олборлолтоороо тэргүүлж буй Казахстан улс нь аж ахуй нэгжийн орлогын албан татварын хэмжээг 20 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн 6 хувиар тогтоосон байна. 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн зөвхөн 2025 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 9 хувь хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. 2026 оноос хойш төлөх татварын хувь, хэмжээг олборлосон дүнгээс хамааруулан 4-18 хувь байхаар шийдвэрлэсэн байна. Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувьд тайлант хугацаанд ураны шар нунтаг (U3O8)-ийн үнэ тодорхой босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд 2026 оноос хойш татварын хувь хэмжээг 70\$/фунт – 0.5%, 80\$/фунт – 1%, 90\$/фунт – 1.5%, 100\$/фунт – 2%, 110\$/фунт – 2.5%-иар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ҮР ДҮН

А. Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

Монгол Улсын Их Хурлаас 2009 онд баталсан Цөмийн энергийн тухай хууль нь 8 бүлэг, 51 зүйлтэй бөгөөд нийт 15 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 8 бүлэг, 38 зүйлийн хэсэг, заалтад өөрчлөлт орсон байна.

Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага болон олон улсын сайн туршлагыг тандан судалсны үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуульд ” Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасныг баримтлан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр оруулсан.

Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр цацраг идэвхт ашигт малтмалыг эдийг засгийн эргэлтэд оруулах, олборлох, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны зарчмын шаардлагуудыг тусгаж дараах өөрчлөлтийг оруулсан.

4.2.Гадаад улсын цацраг идэвхт хаягдал, ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглоно.

5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.

8.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.4.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх.

9.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.9.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9.1.10.цацраг идэвхт ашигт малтмалын ордын талбайн хил заагийг тогтоох.

12.2.Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/-ийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.5-д заасны дагуу олгож, цуцална.

20¹ дүгээр зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

20¹.1.Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон цацраг идэвхт ашигт малтмал экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна.

20¹.2.Энэ хуулийн 201.1-д заасан төлбөр төлөгчийн экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан тооцно.

20¹.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээний 5 хувиар ногдуулна.

20¹.4.Энэ хуулийн 20¹.3-т заасан үндсэн хувь дээр цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллароор/	Үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь
Уран	фунт		0-50 хүртэл	0.00
			50-60 хүртэл	1.00

		Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U ₃ O ₈)	60-70 хүртэл	2.00
			70-80 хүртэл	3.00
			80-90 хүртэл	4.00
			90-100 хүртэл	5.00
			100-110 хүртэл	6.00
			110-120 хүртэл	7.00
			120-130 хүртэл	8.00
			130 ба түүнээс дээш	9.00

20¹.5.Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

20¹.6.Энэ хуулийн 20¹.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

20¹.7.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөхөд Ашигт малтмалын тухай хуулийн 47.6-д заасны дагуу Засгийн газраас баталсан журмыг баримтална.

20¹.8.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана.

20¹.9.Цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг Засгийн газар нийтэд зарлана.

20¹.10.Төлбөр төлөгч цацраг идэвхт ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан тухай бүр татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримт үйлдэх бөгөөд уг төлбөрийн баримтад цацраг идэвхт ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнг тусгасан байна.

20¹.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.7.3-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын албанаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор татварын албанд тус тус тайлагнана.

20¹.12.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

28.2.11.цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх;

30.1.Энэ хуулийн 15.1.2, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой

хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 20 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

30.1.1.тогтворжуулах татварын орчныг тогтоох;

30.4.Улсын Их Хурал энэ хуулийн 5.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх шийдвэрийг гаргасан тохиолдолд компанийн энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж болно.

34.3.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүдрийн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, туршилтын үйл ажиллагаанаас үүссэн цацраг идэвхт хаягдлын менежментийг бүрэн гүйцэтгэж, олон улсын болон үндэсний дүрэм, журам, заавар, стандартад заасны дагуу аюулгүй булшлах үүрэгтэй.

34.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацраг идэвхт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд дараах шаардлагыг биелүүлнэ:

34.4.1.цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах;

34.4.2.үйл ажиллагааны явцад гарсан осол, зөрчлийн талаар цөмийн болон цацрагийн хяналтын асуудал хариуцсан төрийн байгууллага, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагад даруй мэдээлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх;

34.4.3.Цөмийн энергийн комиссоос баталсан хөтөлбөрийн дагуу цацрагтай ажиллагчийг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах.

34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэл ашиглах, эсхүл Монголбанкна дахь валютын тусгай дансанд байршуулах бөгөөд гагцхүү зориулалтын дагуу ашиглана.

34.6.Энэ хуулийн 34.5-д заасан мөнгөн хөрөнгийг тооцоолох, байршуулах журмыг Засгийн газар батална.

34.7.Энэ хуулийн 15.2.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэр эхлэхээс өмнө уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж, 5 жил тутам шинэчлэн цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах бөгөөд уурхай, үйлдвэрийг хаахаас 5-аас доошгүй жилийн өмнө хаалтын төлөвлөгөөг эцэслэн батлуулна.

34.8.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу улсын төсөвт төлнө [5].

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн 2024 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” УИХ-ын тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Монгол Улсын Засгийн газраас Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Бүгд Найрамдах Франц Улсад бүртгэлтэй “Орано Майнинг” хувьцаат компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсон тухай УИХ-ын тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр тус тус батлагдаж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсан.



Зураг 1. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын “Орано Майнинг С.А.С” компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээнд тулууд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа

Б. Цөмий эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглахтай холбоотойгоор Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц

Монгол Улс цөмийн энергийн салбарт 1972 оноос хойш Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай конвенц зэрэг 10 орчим олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон бөгөөд эдгээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсээр ирсэн [6].

УИХ 2009 онд Цөмийн энергийн тухай хууль болон Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг баталж, УИХ-аас 2010 онд батлан гаргасан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.4.4-т “Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.”, 3.5.4.4-т “Түүхий нүүрсийг дулааны аргаар гүн боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх замаар эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний цэвэр түлш үйлдвэрлэх, аливаа үйлдвэрлэлийн технологид хэмнэлттэй, дэвшилтэт байх шаардлагыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан тавина. Нар, салхины сэргээгдэх эрчим хүч ашиглалтыг нэмэгдүүлж, цөмийн эрчим хүчийг ашиглана.” гэж тус тус заасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-д нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилт тусгагдаж, Монгол Улсын Их хурлын 2024 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.7-д “Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж суурь судалгааг хийнэ” гэж тусгасан бөгөөд ОУАЭА-аас цөмийн эрчим хүч барьж байгуулахаар төлөвлөж буй 27 улсын жагсаалтад Монгол Улсыг оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолоор “Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц”, “Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт” болон “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д нэгдэн орох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Тус Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор уг конвенц, конвенцын нэмэлт, өөрчлөлт, протоколд нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар уг конвенц, конвенцын нэмэлт, өөрчлөлт, протоколыг дэмжсэн болно.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг тус тус соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалуудыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд 2024 оны 10 дугаарын 13-ны өдөр баталсан.

Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг тус тус хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурал хуулийн төслүүдийг 2024 оны 11 сарын 29-ны өдөр хэлэлцэн соёрхон баталсан.

Монгол Улс тус конвенц, конвенцын нэмэлт, өөрчлөлт, протоколд нэгдэн орсноор олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааны дэглэмийг ханган тогтвортой байдлыг сахих, цөмийн төхөөрөмжөөс үүсэх ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, хүрээлэн буй орчныг хамгаалах, болзошгүй цацрагийн ослын үед үр дүнтэй хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, энхийн зорилгоор ашиглах цөмийн материалыг аюулгүй тээвэрлэх, биечлэн хамгаалах тогтолцоог олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн бий болгох, хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэлхий дахинд ашиглагдаж байгаа цөмийн материалыг энхийн үйл ажиллагаанд зориулж буй гэдгийг баталгаажуулан дүгнэлт гаргадаг Олон улсын байгууллагатай хамтран ажиллах нөхцөл бүрдсэн юм.

Цөмийн аюулгүй ажиллагааны конвенцид нэгдэн орсноор цөмийн эрчим хүчийг ашиглахад цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм, хүрээлэн буй орчныг хамгаалах хяналтын тогтолцоог бий болгох, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авах боломжтой болсон. Цөмийн эрчим хүчний станцтай шууд холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй бүх байгууллага цөмийн аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах бодлого боловсруулж, мөрдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Цөмийн байгууламжийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд тухайн байгууламжид ажиллагсад болон хүн амд үзүүлэх цацрагийн шарлагын хэмжээг байж болох хамгийн бага түвшинд байлгах нөхцөлийг хангах, цөмийн байгууламжийн биет байдал, түүний үйл ажиллагаа нь зураг төсөл, аюулгүй ажиллагааны холбогдох үндэсний шаардлагууд болон үйл ажиллагааны нөхцөл, хориг хязгаарлалтад нийцэж буй эсэхийг судалгаа шинжилгээ явуулах, туршилт, шалгалт хийх замаар тогтоож баталгаажуулах, цацрагийн осолд өртөх магадлалтай байвал цөмийн байгууламжийн хөрш зэргэлдээ орших өөрийн хүн ам болон эрх бүхий байгууллагуудыг ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, хариу арга хэмжээний талаар холбогдох мэдээллээр хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авах шаардлагатай.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалын аюулгүй байдлыг хангах асуудлыг хамаарч байна. Мөн конвенцод хамаарах гэмт

хэрэгт цөмийн материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж, хорлон сүйтгэх ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсон улс орон бүр цөмийн материалыг хулгайлах, хууль бусаар эзэмших, эдгээр учирч болох бодит аюул бий болсон тохиолдолд ОУАЭА-т нэн даруй мэдэгдэх шаардлагатай. Энэхүү мэдээллийг үндэслэн тухайн улс өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд бусад орон, холбогдох олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалтыг олон улсын түвшинд хүргэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчныг бий болгох нөхцөл бүрдсэн.

Бага хэмжээний хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсон улс орнууд ОУАЭА-аас томилсон хяналт, шалгалтын байцаагч нарын томилгоог хүлээн авах, шаардлагатай тохиолдолд хил нэвтрэх эрх олгох, эрхийг шинэчлэх зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, анхны тайланд тодорхойлсон байршил болон цөмийн материалын байршилд нэвтрэх эрхийг бүрэн олгох үүрэгтэй.

Мөн Иж бүрэн баталгааны гэрээний дагуу тухайн улс орон ОУАЭА болон түүний хяналт, шалгалтын үүрэг гүйцэтгэж буй байцаагч нарт “ОУАЭА-ийн халдашгүй дархан эрхийн тухай гэрээ”-ний холбогдох заалтуудад тусгасан давуу эрх, халдашгүй байдлыг хангах үүрэгтэй.

Монгол Улс нь бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орсноор өөрийн онцлог, нөхцөл байдалд тохирсон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, цөмийн аюулгүй байдлын баталгааг гүйцэтгэх, хянах техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийг бий болгох чиглэлээр ОУАЭА-ийн зөвлөх үйлчилгээ авах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах боломж бүрдэж, улмаар цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэхэд олон улсын баталгааны шаардлагыг хангахад алхам ойртсон.

В.Дүрэм, журам, стандартын шинэчлэлт

Хурдацтай явагдаж буй нийгэм эдийн засаг, шинжлэх ухаан, цөмийн технологийн хөгжилтэй уялдуулж, олон улсын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, стандартуудыг үндэслэн, Монгол Улсын Цөмийн энергийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн “Цацрагийн аюулгүйн норм”, “Цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”-ийг Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас зохион байгуулж боловсруулсан. Улмаар Цөмийн энергийн комиссын дэргэдэх Цацрагийн аюулгүйн зөвлөл, Цөмийн энергийн комиссын хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн “Цацрагийн аюулгүйн норм”-ыг Цөмийн энергийн комиссын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор, “Цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”-ийг Цөмийн энергийн комиссын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан.

Цөмийн энергийн комиссын “Норм, дүрэм батлах тухай” 2015 оны 06 дугаар тогтоолыг Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн Улсын нэгдсэн бүртгэлд 2015 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр, Цөмийн энергийн комиссын “Дүрэм батлах тухай” 2016 оны 01 дүгээр тогтоолыг 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тус тус бүртгүүлснээр Цацрагийн аюулгүйн норм, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Энэхүү норм, дүрмээр цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материалыг импортлох, ашиглах, хадгалах, тээвэрлэх, экспортлох, цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох, боловсруулах, цацраг

идэвхт хаягдлын менежмент хийх, цацраг идэвхт өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэх, ашиглах, цөмийн төхөөрөмж барих, ашиглах, ашиглалтаас гаргах зэрэг цацрагтай холбоотой бүхий л үйл ажиллагаанд тавигдах цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлагуудыг тогтоосон билээ. ОУАЭА-ийн стандарт болон Европын холбооны дүрэм стандартыг судлан Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цацрагийн аюулгүйн нормд нийцүүлэн салбар бүрт хэрэглэгдэж буй цөмийн технологи, цөмийн төхөөрөмж, цөмийн хэмжүүр, цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт материал болон цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой үйл ажиллагааны онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны тусгай шаардлагуудыг тогтоосон дараах дүрэм, журам, стандартыг Цацрагийн аюулгүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газар, Цөмийн энергийн комисс, Стандарт, хэмжил зүйн газраар батлуулсан [7], [8].

№	Дүрэм, стандартын нэр	Баталсан тогтоол	Улсын нэгдсэн бүртгэл
1	Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм	ЦЭК-ын 2016 оны 02 дугаар сарын 16-ний өдөр, 01 дүгээр тогтоол	Дугаар 3639 /2016.06.02/
2	Цацрагийн аюулгүйн норм	ЦЭК-ын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоол	Дугаар 3557 /2015.09.21/
3	Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм	Засгийн газрын 2019 оны 243 дугаар тогтоол	-
4	Цөмийн материалыг бүртгэх, хянах журам	Засгийн газрын 2020 оны 229 дүгээр тогтоол	-
5	Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө	Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоол	-
6	Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм	Засгийн газрын 2022 оны 445 дугаар тогтоол	-
7	Цөмийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн төлөвлөгөө	ЦЭК-ын 2015 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоол	-
8	Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэм	ЦЭК-ын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоол	Дугаар 3610 /2016.02.03/
9	Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, судалгааны цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм	ЦЭК-ын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 13 дугаар тогтоол	Дугаар 3616 /2016.03.03/
10	Цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм	ЦЭК-ын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоол	Дугаар 3905 /2018.05.17/
11	Хүдрийн олборлолт, боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрэм	ЦЭК-ын 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоол	Дугаар 3622 /2016.03.10/
12	Суурин цөмийн хэмжүүр ашиглахад мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм	ЦЭК-ын 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тогтоол	Дугаар 3810 /2017.12.12/
13	Зөөврийн цөмийн хэмжүүр ашиглахад мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм	ЦЭК-ын 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоол	Дугаар 3811 /2017.12.12/
14	Цооногийн каротажийн судалгаанд цацраг идэвхт битүү үүсгүүр ашиглахад мөрдөх цацрагийн аюулгүйн дүрэм	ЦЭК-ын 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоол	Дугаар 3812 /2017.12.12/
15	Газрын дор хүчлээр уусган уран олборлоход мөрдөх техникийн зохицуулалт	Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 160 дугаар тогтоол	-
16	Монгол улсын стандарт MNS 0442:2015	Стандартчиллын үндэсний зөвлөлийн	-

	“Техникийн хүхрийн хүчил. Техникийн шаардлага”	2015 оны 04 дүгээр сарын 16-ны хурал	
17	Монгол улсын стандарт MNS ASTM C 967:2015 “Ураны хүдрийн баяжмал /шар нунтаг/-д тавих техникийн ерөнхий шаардлага”	Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 16-ны хурал	-
18	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүйн албаны дүрэм	ЦЭК-ын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоол	Дугаар 3557 /2015.09.21/
19	Үйлдвэрийн рентген радиографийн цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм	ЦЭК-ын 2022 оны 11 дүгээр тогтоол	-
20	Байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай холбоотой үйл ажиллагаанд цацрагийн мониторинг хийх журам	ЦЭК-ын 2024 оны 02 дугаар тогтоол	-

ДҮГНЭЛТ

Монгол Улсад цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулах, цацраг идэвхт ашигт матлмалыг эдийн засгийн эргэлтэд оруулахад Цөмийн энергийн тухай хууль болон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулахтай холбоотой 20 баримт бичгийг батлан гаргасан нь эрх зүйн орчинг олон улсын жишигт хүргэх чиглэлд чухал алхам болсон.

Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах, аюулгүй байдал, аюулгүй ажиллгаа, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх чиглэлээр дээрх олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсноор Монгол Улсын цөмийн энергийн энхийн хэрэглээнд олон улсын баталгааны шаардлага хангагдаж, цөмийн зэвсгээс ангид байх статусаа шинэ түвшинд гаргалаа.

Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд цацрагийн аюулгүй ажиллагааны соёлыг хэвшүүлж, энэ асуудлыг байгууллагын удирдлагын түвшинд авч үзэж байх шаардлагатай юм. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дүрэм, норм, стандартууд нь ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, осол аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цацрагийн аюулгүй ажиллагааны соёлыг хэвшүүлэхэд нэн чухал ач холбогдолтой байна.

Цаашид Монгол Улсын цөмийн энергийн салбарт баримтлах бодлогод уялдуулан цөмийн төхөөрөмж болон цөмийн эрчим хүчний станцын загвар, газар сонголт, ашиглалт, хаягдлын менежмент болон аюулгүй ажиллагааны үнэлгээтэй холбоотой дүрэм, журам, стандартыг батлуулан гаргах хэрэгцээ шаардлага зүй ёсоор тулгарч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[1] Цацрагийн аюулгүйн норм ЦАН-83;

[2] Цацрагийн ариун цэврийн үндсэн дүрэм ЦАЦҮД-83;

[3] Radiation Protection and Safety of Radiation Sources: International Basic Safety Standards, General Safety Requirements Part 3, No. GSR Part 3, IAEA, https://www-pub.iaea.org/MTCD/Publications/PDF/Pub1578_web-57265295.pdf;

- [4] Red book 2022, OECD/NEA and IAEA Uranium group, https://www.oecd-neo.org/jcms/pl_28569/uranium-resources-production-and-demand-red-book.
- [5] Цөмийн энергийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/97>;
- [6] Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, <https://nea.gov.mn/filepage/2dHHLiDoEjNVlsVGSNNvRl>
- [7] Засгийн газар, Цөмийн энергийн комиссын 2015-2024 оны тогтоолууд. <https://nea.gov.mn/filepage/4vgQiaERjfpE13Nymyc4jX>;
- [8] MN3.01/12, “Монгол улсад цацрагийн аюулгүй ажиллагаа, цөмийн аюулгүй байдлын баталгаа, цөмийн аюулгүйн хяналтыг сайжруулах” төслийн тайлан;

Abstract

Since the legal framework for radiation protection and safety in Mongolia, including the rules and regulations used in daily operations, had not been updated since 1983, the International Atomic Energy Agency standards, the experiences of the European Union and other countries were studied and national regulations developed in line with international standards. Within the framework of this work, 20 rules, regulations, norms, standards, and plans were developed and approved in the field of radiation protection, safety, security and safeguards. Mongolia has joined international treaties and conventions in the fields of peaceful use of nuclear energy, safety, security and non-proliferation of nuclear weapons. The Law on Nuclear Energy was also amended to include radiation protection and safety requirements for the mining and milling of radioactive minerals.